



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 108

Номгон

Хуулийн этгээд байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООНЬ:

- 1.Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 100 хүүхдийн суудал бүхий улсын төсвийн санхүүжилттэй 15 дугаар цэцэрлэгийг үүсгэн байгуулсугай.
- 2.Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны дүрмийг хавсралтаар баталсугай.
- 3.Цэцэрлэгийн үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу олгож, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА
Ц.ОТГОНБАЯР

БАЯНХОНГОР СУМЫН АРВАН ТАВДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Баянхонгор сумын арван тавдугаар цэцэрлэг нь /цаашид “цэцэрлэг” гэх/ Монгол Улсын Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, бусад хууль, эрх зүйн акт, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийг өдөр тутмын үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллана.

1..2 Цэцэрлэг нь сургуулийн өмнөх насын хүүхдийн нас, бие сэтгэхүйн онцлогт тохирсон мэдлэг, чадвар дадал эзэмшүүлэх хүмүүжлийн зөв хэвшил төлөвшүүлэх үүрэг бүхий сургалтын байгууллага байна.

1.3. Цэцэрлэг нь өөрийн хөдөлмөрийн харилцааг зохицуулсан дотоод журмыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж мөрдүүлнэ.

1.4. Цэцэрлэг нь орон нутгийн боловсролын удирдах байгууллагаас гаргасан мэргэжлийн удирдамж чиглэлийг баримтлана.

1.5 Цэцэрлэг нь байгууллага хөгжүүлэх үзэл баримтлал, хэтийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байна.

1.6. Цэцэрлэг нь ардчилал ил тод нээлттэй байдал, хамтын улирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа зохион байгуулна.

1.7. Цэцэрлэг нь өөрийн үйл ажиллагааны талаар эцэг эх асран хамгаалагчдын мэдээлэл авах эрхийг хангаж ажиллана.

1.8. Цэцэрлэгт эрхлэгч, арга зүйч, туслах багш, эмч, тогооч, нягтлан, үйлчлэгч болон хууль тогтоомжоор зөвшөөрсөн цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахад шаардлагатай бусад ажилтнууд ажиллана.

1.9. Цэцэрлэг нь хуулийн этгээд бөгөөд зохих журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

1.10. Цэцэрлэг нь тойргийн 2-5 насын хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгоно.

1.11. Цэцэрлэг нь Хүүхдийн эрхийн тухай олон улсын гэрээ, конвенци, үндэсний хууль тогтоомжид нийцсэн “хүүхэд хамгааллын бодлого” –ыг хэрэгжүүлнэ.

1.12. Цэцэрлэг бүрийн дэргэд цэцэрлэгийн төлөөлөл, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн цэцэрлэгийн зөвлөлтэй байх бөгөөд Цэцэрлэгийн зөвлөлийн ажиллах журмыг тусгайлан батлан мөрдөж ажиллана

1.13. Хүүхдийн дунд зохион байгуулах сургалт хүмүүжлийн ажлын чанарыг сайжруулах боловсролын талаар цэцэрлэгийн хэмжээнд баримтлах үндсэн гол асуудлыг зөвшин хэлэлцэж тодорхой шийдвэр гаргах үүрэг бүхий “Цэцэрлэгийн багш нарын зөвлөл”-ийг байгуулан ажиллах журмыг тусгайлан батлан мөрдөж ажиллана.

1.14. Цэцэрлэгийн хүүхдийн сургалт хүмүүжлийн ажлын арга зүйг боловсронгуй болгох чанарыг дээшлүүлэх багш нарын сурган хүмүүжүүлэх чадвар арга барилыг сайжруулах ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх, хяналт тавих зорилгоор “Цэцэрлэгийн заах аргын нэгдэл”-ийг байгуулж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаын шийдвэр зааврын дагуу ажиллуулна

1.15. Цэцэрлэгийн орчин хүүхдэд эрүүл аюулгүй байх нөхцөл боломжийг бүрдүүлсэн холбогдох стандарт, эрх зүйн баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.

1.16. Цэцэрлэг нь боловсрол шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрмийг мөрдөж ажиллахын зэрэгцээ өөрийн цэцэрлэгийн онцлогт нийцүүлэн аюулгүй байдлын дүрмийг батлан мөрдөж ажиллаж бол.

1.17. Цэцэрлэг нь харилцан хүлээх эрх үүргийг тусгасан гурвалсан гэрээг хүүхдийн эцэг эх асран хамгаалагчтай хичээлийн жил өхэлмэгц тусгайлан байгуулна.

1.18. Цэцэрлэг бүр тухайн хичээлийн жилийн эхний сардаа багтан өөрийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм журам, бодлого шийдвэрийг эцэг эхчүүдэд танилцуулах хүргэх ажлыг зохион байгуулна.

1.19. Хүүхэд хамгааллын бодлого, цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрдлөгөө болгодог бусад дүрэм журмыг нэгтгэн эмхтгэж цэцэрлэгийн төсвөөс хэвлүүлж багш ажилтан, эцэг эхчүүдэд ил тод нээлттэй чөлөөтэй танилцах боломжоор хангана.



Хоёр. Цэцэрлэгийн бүтэц, удирдлага

2.1. Цэцэрлэгийн өөрийн удирдлагыг цэцэрлэгийн зөвлөл, эрх зүйн мэргэжил арга зүйн удирдлагыг цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч хэрэгжүүлнэ.

2.2. Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч багш нь сурган хүмүүжүүлэх чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

2.3. Цэцэрлэг нь хууль тогтоомжийн хүрээнд эцэг эхийн санал хүсэлтэд үндэслэн ажиллах цагийг уян хатан тогтоож уртасгасан богиносгосон 24 цагийн ажиллагаатай бүлэг байгуулж болно. Эцэг эх асран хамгаалагчаас шалтгаалан багш илүү цагаар ажилласан тохиолдолд эцэг эхээс төлбөр авах асуудлыг цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэр эцэг эхтэй байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

2.4. Цэцэрлэгийн хүүхдийг насын ангиллаар бага, дунд ахлах бэлтгэл, холимог бүлгээр зохион байгуулж хүүхдийн эрүүл аюулгүй сурч хөгжих орчин нөхцөлийг хангасан байхаар төлөвлөн зохион байгуулна.

2.5. Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1-2 хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болно.

Гурав. Хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Цэцэрлэгийн хичээлийн жил 9 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжилнэ.

3.2. Цэцэрлэг нь бүлэг дэвших шинээр орох хүүхдийн элсэлтийг жил бүрийн 8 дугаар сарын 25-наас 8 дугаар сарын 28-ны хооронд хийнэ.

3.3. Цэцэрлэг нь бага насын хүүхдийг асран хамгаалах тэдний бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг хангах үйл ажиллагаа зохион байгуулахын зэрэгцээ эцэг эх нь хүүхдээ хөгжүүлэх хүмүүжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.4. Цэцэрлэгт багш, ажилтан, хүүхэд, эцэг эхийн бие биенээ хүндэтгэсэн дэмжсэн дотно харилцаа идэвхтэй оролцоо эерэг уур амьсгалыг бүрдүүлж хүүхдийн эрхэд суурилсан бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хүүхэд бүрт ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэх эрхэм зорилгоо болгож ажиллана.

3.5. Бага насын хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаандaa хүүхдийн эрх, нас сэтгэхүй, хөгжлийн түвшин хүүхэд бүрийн онцлог байдал, хэрэгцээ сонирхолд нийцсэн байна.



3.6. Цэцэрлэг нь “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр”, хүүхэд бүрийн насны онцлог бүлгийн хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үе шатанд тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулан мөрдөнө.

3.7. Цэцэрлэг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын зөвшөөрөлтэйгээр сурган хүмүүжүүлэх туршилт явуулж болно.

3.8. Цэцэрлэг нь үндэсний уламжлалт зан заншил өв соёл, эрүүл мэндийн боловсролын анхны мэдэгдэхүүн эзэмшүүлэх чиглэлээр нэмэлт сургалт зохион байгуулж болно.

3.9. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тэднийг эрүүлжүүлэх чийрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.

3.10 Цэцэрлэгийн анги танхимыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн аюулгүй орчин бүрдүүлэхээр засаж тохижуулсан байна.

Дөрөв. Цэцэрлэгийн эрх

4.1. Батлагдсан төсөвт багтаан ажилтны орон тоо, норматив, статистик мэдээнд өгөгдсөн хүүхдийн тоог барин ажиллана.

4.2. Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, болон бусад эрх зүйн баримт бичгийг үндэслэн цэцэрлэгийн багш ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх, шагнаж урамшуулах шагналд тодорхойлох тэдэнд сахилгын шийтгэл эд материалын хариуцлагыг эрхлэгч хүлээлгэнэ.

4.3. Батлагдсан төсөв хөрөнгийг ашиглан сургалтын техник хэрэгсэл тоног төхөөрөмж зэрэг эд хөрөнгө худалдан авч хэрэгцээ хангахгүй болсон илүүдэлтэй элэгдэж хуучирсан эд хөрөнгийг зохих журмын дагуу актлана.

4.4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм журмын дагуу гадаад дотоодын байгууллага, цэцэрлэг иргэдтэй гэрээ хэлцэл байгуулан үр ашигтай хамтран ажиллана.

4.5. Батлагдсан цалинг үндэслэн багш ажилтны цалинг хууль тогтоожийн дагуу тогтоон, үр чадварын болон зэрэг дэвийн нэмэгдэл олгож, шаардлагатай үед тэтгэмж олгоно.

Тав. Цэцэрлэгийн нийтлэг үүрэг

5.1. Цэцэрлэгийн хүүхэд нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон хүмүүжил сургалтын ажлыг чанартай зохион байгуулж явуулах тэдний авьяас сонирхолыг

хөгжүүлэх ариун цэвэр аюулгүй ажиллагааны дэг журмыг чанд сахиж эрүүл мэндийг нь хамгаалан бэхжүүлэх, хамт олны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах материаллаг баазаа бэхжүүлэх, хүмүүжил сургалтын ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгыг амжилттай шийдвэрлэхийн тулд цэцэрлэгийн үйл ажиллагааны хэтийн болон ойрын ажлын төлөвлөгөөг боловсруулан мөрдөж биелэлтэд хяналт тавьж ажиллана.

5.2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүмүүжил сургалтын хөтөлбөрийн агуулгаар хамран сургах тойргийнхоо хүүхдийн дунд сургалт зохион байгуулж хүүхдийг сургуульд амжилттай бэлтгэх зорилтыг хэрэгжүүлж ажиллана.

5.3. Цэцэрлэгийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явцад эцэг эх, гэр бүлийн гишүүдийнг татан оролцуулах тэдний ухамсартай идэвхтэй байнгын дэмжлэгийг бий болгоход анхаарч эцэг эх цэцэрлэгийн хамтын ажиллагааг бэхжүүлж ажиллана.

5.4. Цэцэрлэгийн хүүхдэд амт чанар илчлэг сайтай олон нэр төрлийн хоолоор үйлчилнэ. Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тэдний хувийн ариун цэврийг сахиулах халдвар өвчинөөс урьдчилан сэргийлэх Цэцэрлэгийн эрүүл ахуйн дэглэмийг чанд мөрдүүлэх, арга хэмжээ авч ажиллах ба багш ажилчдыг жилд хоёр удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, төсвөөс мөнгийг гаргана.

5.5. Төрийн захиргааны төв байгууллагаас баталж гаргасан хүүхдийн цэцэрлэгийн багшийн ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн цэцэрлэгийн багш ажилтны ажил үүргийн хуваарь ажлын чиглэлийг тодорхойлсон гэрээний дагуу ажилд авч ажиллах нөхцөлөөр хангана.

5.6. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу цэцэрлэгийн багш нарын ажлыг тодорхой шалгуур үзүүлэлтээр шалган түвшин тогтоож мэргэжлийн зэрэг олгон цалин хөлс нэмэгдлийн ажлын үр дүнгээр олгоно.

5.7. Цэцэрлэгийн орчин нь сургуулийн өмнөх насны хүүхэд бүрийн эрүүл аюулгүй сурч хөгжих таатай орчин бүрдүүлсэн байна.

5.8. Цэцэрлэгийн орчин нь холбогдох стандарт эрх зүйн баримт бичигт заасны дагуу хүүхдэд эрүүл аюулгүй сурч хүмүүжих нөхцлийг хангасан байна.

5.9. Цэцэрлэг нь өөрийн үйл ажиллагаанд мөрдлөг болгох аюулгүй ажиллагааны заавар журмыг батлан мөрдүүлнэ.

5.10. Цэцэрлэгийн нээлттэй ил тод байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн жил бүр эцэг эхчүүдэд тайлагнана.

Зургаа. Цэцэрлэгийн эрхлэгчийн эрх үүрэг

6.1. Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж эрх зүйн бусад акт шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.

6.2. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр, сургалтын бодлогыг хэрэгжүүлэх хүүхдийн эрүүл таатай орчныг бүрдүүлэх хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

6.3. Цэцэрлэгийн эрхлэгч арга зүйч нь хүүхдийн хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах, нэвтрүүлэх, ажлыг зохион байгуулж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж сургалтын үйл ажиллагаа үр дүнд хяналт тавьж ажиллана.

6.4. Багш ажилчдын мэдлэг мэргэшил ур чадварыг эзэмшилүүлэх тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

6.5. Ажилтан нь ямар нэгэн байдлаар хүүхдийн эрхийг зөрчсөн хүчирхийлэл үйлдсэн нь тогтоогдвол шуурхай арга хэмжээ авч хариуцлага тооцох бөгөөд хүүхдийн хүмүүжилдд сөрөг нөлөө үзүүлсэн ажилтныг цаашид ажиллуулахгүй байх бодлого баримтлана.

6.6. Ажилтнууддаа хүүхдийн осол аюулгүй байдлыг ханган ажиллах зааварчилгаа цэцэрлэгийн аюулгүйн зураглал холбогдох дүрэм журмыг сахиж ажиллах талаар заавар зөвлөгөөгөөр тухай бүр хангаж ажиллана.

6.7. Цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай засвар үйлчилгээ хийлгэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд санаачилгатай анхаарч ажилладаг байх.

6.8. Цэцэрлэгийн төсөв бусад санхүүжилтийн эх үүсвэрээс орж ирсэн хөрөнгийг эцэг эх багш ажилтнуудын саналд тулгуурлан оновчтой төлөвлөх зөв зарцуулах хянах тайлагнана.

6.9. Цэцэрлэгийн эрхлэгч нь багш нарын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулахад зориулан долоо хоногт 1-2 цагийн зохицуулалт хийж өгнө.

Долоо. Цэцэрлэгийн арга зүйч багшийн эрх үүрэг

7.1. Цэцэрлэгийн арга зүйч багш нь сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжилтэй хүн байна.



7.2. Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх, засан сайжруулах ажлыг зохион байгуулна.

7.3. Арга зүйч багш нь сургалтын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж үнэлгээ дүгнэл өгч цаашид боловсронгуй болгоход анхаарч ажиллана.

7.4. Багш туслах багшид сургалт хүмүүжлийн арга зүйн чиглэлээр тогтмол зөвлөгөө өгч сургалт зохион байгуулна.

7.5. Эцэг эхчүүдэд хүүхдийн сургалт хүмүүжлийн талаархи сургалтыг тухайн бүлгийн багштай хамтран зохион байгуулна.

Найм. Цэцэрлэгийн багшийн эрх үүрэг

8.1. Цэцэрлэгийн багш нь /цаашид багш/ гэх багшлах эрхтэй байна.

8.2. Цэцэрлэгийн багш, туслах багш нь Сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтэй, цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгох хууль, тогтоомжийн эрх зүйн бусад акт багшийн ёс зүйн дүрэм энэ дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

8.3. Туслах багш нь хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулахад багшид дэмжлэг үзүүлнэ.

8.4. Цэцэрлэг нь бага насын хүүхдийг хөгжүүлж хүмүүжүүлэх чиглэлээр З кредит цагаа доошгүй хугацааны сургалтад 1-2 удаа хамрагдсан туслах багшийг ажиллуулна.

8.5. Багш нь эцэг эхэд бага насын хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх улмаар хүүхэдтэй ажиллах эв дүй чадвараа сайжруулахад туслалцаа үзүүлэх энэ талаарх сургалтыг зохион байгуулна.

8.6. Цэцэрлэгийн зөвлөл эцэг эхийн зөвлөл тухайн эцэг эхийн санаачилга зөвшөөрөлтэйгээр хийгдснээс бусад асуудлаар хүүхдийн эцэг эх асран хамгаалагчаас санхүүгийн болон бусад дэмжлэг авах авахаа шаардахыг хориглоно.

Ес. Бусад ажилтнуудын эрх үүрэг

9.1. Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах бусад ажилтнууд нь холбогдох хууль тогтоомж энэ дүрэм, хүүхэд хамгааллын бодлого, цэцэрлэгийн аюулгүй ажиллагааны дүрэм байгууллагын дотоод журам өөрсдийн үйл ажиллагаанд хамааралтай бусад дүрэм журмыг дагаж мөрдөнө.



9.2. Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахад бусад ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг хууль тогтоомж ажлын онцлогт нийцүүлэн цэцэрлэгийн эрхлэгч батална.

9.3. Цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах бусад ажилтнууд нь цэцэрлэгтээ хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд анхаарч цэцэрлэгийн удирлага багш бусад ажилтануудтай нягт хамтран ажиллана.

Арав. Хүүхдийн эрх, үүрэг

10.1. Хүүхэд нь Хүүхдийн эрхийн тухай конвеци Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, болон бусад хууль тогтоомж эрх зүйн бусад акт энэ дүрмэнд заасан эрхийг эдлэх эрхтэй.

10.2. Хүүхэд цэцэрлэгийн орчинд бие махбодь сэтгэл санааны дарамт хэл амаар доромжууллах, ялгаварлан гаруурхагдах, аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй.

10.3. Хүүхэд эрүүл аюулгүй байх стандарт, шаардлагад нийцсэн орчинд сурч хүмүүжих эрхтэй.

10.4. Хүүхдийн хөгжилд тохирсон сургалтын хүртээмжтэй хэрэглэгдэхүүнээр хангагдах, хүүхэд сурч хүмүүжих таатай орчноор хангагдах эрхтэй.

10.5. Хүүхэд эрүүл аюулгүй чанарын шаардлагад нийцсэн хоол хүнсээр хангагдах эрхтэй.

Арван нэг. Эцэг эхийн эрх

11.1. Хууль тогтоомж энэ дүрэм, цэцэрлэгийн үйл ажиллагаанд баримтлах бусад дүрэм, журам заавар гурвалсан гэрээнд заасан эрхийг эдлэнэ.

11.2. Цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлэх сургалт хүмүүжлийн ажил чанар үр дүнг сайжруулахад дэмжлэг үзүүлэх цэцэрлэг эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Эцэг эхийн зөвлөл”-ийг баталж ажиллуулна.

11.3. Цэцэрлэгийн үйл ажиллагаа үйлчилгээний талаар үнэлгээ өгөх, сайжруулахын тулд өөрийн санал бодлоо илэрхийлэх, хяналт тавих эрхтэй.

11.4. Цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжигч байх бөгөөд цэцэрлэгийн үйл ажиллагаа хүүхдийн хөгжил сурч хүмүүжих орчныг сайжруулах зорилгоор эд материал санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх эрхтэй.

11.5. Эцэг эхчүүд цэцэрлэгийн удирдлага ангийн багштай зөвшилцсний үндсэн дээр хүүхдийг хөгжүүлэх хүүхдийн сурч хүмүүжих таатай орчныг бүрдүүлэх



зорилгоор тодорхой зохион байгуулалттай ажил сургалтыг цэцэрлэг дээр өөрийн үүсэл санаачилгаар зохион байгуулах эрхтэй.

11.6. Цэцэрлэгийн багш, ажилтнуудын харилцаа ёс зүй үйлчилгээний талаар санал хүсэлт гомдол гаргах эрхтэй.

Арван хоёр. Эцэг, эхийн үүрэг

12.1. Хууль тогтоомж энэ дүрэм цэцэрлэгийн үйл ажиллагаанд баримтлах бусад дүрэм журам заавар гурвалсан гэрээний заалтыг биелүүлэх үүрэгтэй.

12.2. Хүүхдийнхээ хөгжил сурах үйл ажиллагаанд туслах мэдлэг, чадвар эзэмшихэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх тэдний сурсан зүйлийг улам бүр бататган хөгжүүлэхэд анхаарах үүрэгтэй.

12.3. Цэцэрлэгийн багшийн ажлын нөхцөл байдлыг харгалзан үзэж тэдний ажилд хүндэтгэлтэй хандаж эелдэг харилцааг эрхэмлэнэ.

12.4. Цэцэрлэгт хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд анхаарч цэцэрлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

12.5. Эцэг, эх нь өөрийн хүүхдийн хувийн онцлог хөгжлийн талаарх багшид тус болох мэдээллийг байнга өгч хамтран ажиллах үүрэгтэй.

12.6. Эцэг эхийн хүлээх бусад нарийвчилсан эрх үүргийг тухайлсан дүрэм, журмаар зохицуулна.

Арван гурав. Санхүүжилт

13.1. Цэцэрлэгийн үйл ажиллагаанд зориулагдсан төсөв цалингийн сангийн хөрөнгийг зохих ёсоор зөв зарцуулна.

13.2. Цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаа нь бие даасан байна.

13.3. Цэцэрлэг нь төсвийн зарцуулалтын жил, улирлын тайлан тэнцэлд эдийн засгийн судалгаа шинжилгээ хийж хамт олон цэцэрлэгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Тайлан тэнцлийг харьялагдах санхүүгийн байгууллагад хугацаанд нь тушааж холбогдох тооцоог хийнэ.

13.4. Цэцэрлэг нь өөрийн үйл ажиллагаанд зориулан дотоод гадаадын хуулийн этгээд иргэд эцэг эх асран хамгаалагч олон улсын байгууллага төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хамтран ажиллах хэлбэрээр тодорхой хэмжээний хандив, тусламж санхүүжилт авч болно.

13.5. Энэхүү хандив тусламж, аливаа хэлбэрийн санхүүжилт нь хүүхдийн сурч хүмүүжих эрүүл аюулгүй таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

13.6. Цэцэрлэг дээрх аливаа хэлбэрийн санхүүжилтийг авахдаа аливаа ашиг сонирхол, үзэл суртал, шашин байгууллагыг сурталчлах, дэмжих гэх мэт явцуу ашиг сонирхолоос ангид байж гадны нөлөөнд үл автас зарчмыг баримтлана.

13.7. Цэцэрлэг нь энэ дүрмийн 12.4, 13.4 –д заасан хөрөнгийг нэгтгэн төвлөрүүлэх зорилгоор Цэцэрлэгийг хөгжүүлэх сан байгуулж ажиллах бөгөөд сангийн дүрмийг тусгайлан батлан мөрдөнө.

ооо